Захирлын 2019 оны 05 дугаар
сарын 27-ны өдрийн А/90 тоот
тушаалын хавсралт

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН НОМЫН САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. ОТИС-ийн номын сан нь Боловсролын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Номын сангийн орчны үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5742-2007, ОТИС-ийн дүрэм, журам болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.2. ОТИС-ийн номын сан нь сургалт, эрдэм шинжилгээний ажил хийх болон ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр өөрийн сургуулийн багш, ажилтан, докторант, магистрант, оюутан, судлаачдад /цаашид уншигч гэнэ/ номын сангийн үйлчилгээ үзүүлж, ном зүйн мэдээллээр ханган, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах үүрэг бүхий үйлчилгээний нэгж байна.

1.3. Номын сан нь номын сангаар үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан номын сангийн өөрчлөлт, шинэчлэлтийг хийх зорилтуудыг тавьж ажиллана.

1.4. Номын сан нь гадаад, дотоод мэдээллийн сүлжээнд хамрагдаж, олон улсын болон дотоодын номын сангуудын хоорондноом, хэвлэл, мэдээлэл солилцох замаар үйлчилгээнийхээ цар хүрээг өргөжүүлэн ажиллана.

1.5. Номын сан нь өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээгээ энэхүү дүрэм болон дотоод журмаар зохицуулна.

Дөрөв. Уншигчийн эрх, үүрэг

4.1. Уншигч дараах үүрэгтэй

4.1.1. уншигч номын сангийн дотоод журмыг биелүүлэх;

4.1.2. номын сангийн фондоос ном захиалахдаа каталогоос шифрийг олж захиалах;

4.1.3. номын сангаас авсан ном, сурах бичиг, хэвлэлийн бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг хариуцах;

4.1.4. уншигч ном үрэгдүүлж гээгдүүлсэн тохиолдолд зохих журмын дагуу төлбөр төлж номын санг хохиролгүй болгох;

4.1.5. номын санчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

4.2. Уншигч дараах эрх эдэлнэ

4.2.1. ОТИС-ийн профессор багш, ажилтан, суралцагсад сургуулийн номын санд үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

4.2.2. тохитой орчинд цагийн хуваарийн дагуу түргэн шуурхай үйлчлүүлэх;

4.2.3. номын сангийн фондоос ном, мэдээллийг тодорхой хугацаагаар авч ашиглах, лавлагаа зүйн мэдээллийн үйлчилгээ хийлгэх;

4.2.4. каталогоос хайлт хийсний үндсэн дээр өөрийн сонирхсон ном, хэвлэлийг авч хэрэглэх;

4.2.5. номын сангийн үйл ажиллагааны талаар өөрийн санал хүсэлтээ илэрхийлэх;

4.2.6. Ном авахдаа номын сангийн ажилтны дэргэд бүрэн бүтэн байдлыг нь шалгаж, гэмтсэн номыг солиулах эсхүл тэмдэглүүлэх эрхтэй. Тэмдэглүүлээгүй гэмтлийг уншигч өөрөө хариуцна.

--- oOo ---